

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

## ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 21

1. “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

6 - 21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 20 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, С.Зулпхар, О.Цогтгэрэл;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.*

***Нэг. “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Хуулийн зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулж тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Батбаатар, Г.Уянгахишиг, О.Алтангэрэл нар үг хэлэв.

*Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Тогтоолын төслийн “Иргэн бүр Үндсэн хуулиа судлан дээдэлж, айл өрх бүр Үндсэн хуулиа дээдлэн залахыг уриалсугай” гэснийг “Иргэн бүр Үндсэн хуулиа судлан мэдэх боломжтой Үндсэн хуулийн хялбаршуулсан болон зурагт хувилбаруудыг нийт иргэдэд үнэ төлбөргүй хүргэж, айл өрх бүрт Үндсэн хуулиа байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагад даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 14  
Бүгд: 15  
6.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны гишүүд санал хураалтын систем гацсан тул санал хураалтыг гар өргөж явуулъя гэсэн горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны гишүүдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 15  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Тогтоолын төслийн “Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, Монгол Улсын Засгийн газар болон холбогдох төрийн байгууллагад даалгасугай” гэснийг “Үндсэн хуулийн агуулгыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт шинэлэг аргаар тусган, хичээлийн хөтөлбөр болон багш бэлтгэх залуу үед хүний эрх, тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлах цахим тоглоом санаачлахыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад удирдамж болгосугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 12  
Бүгд: 15  
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

---

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Тогтоолын төслийн “Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа, Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, сурталчлахыг хэвлэл мэдээллийн байгууллагад уриалсугай” гэснийг “Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг Үндсэн хуулийн талаар тусгай нэвтрүүлэг, подкаст, социал медиа, контент хөгжүүлэн олон нийтэд хүргэж, залуучуудын оролцоог дэмжихийг уриалсугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 12  
Бүгд: 15  
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, “Энэ тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэснийг “Энэ тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхэлж, жил бүрийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд танилцуулахыг төрийн холбогдох байгууллагуудад даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 13  
Бүгд: 15  
13.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, “Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх” гэсний дараа “нийт байгууллага, иргэдийн үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх” гэсэн хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 11  
Бүгд: 15  
26.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

**Ж.Бат-Эрдэнэ:** “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 7  
Бүгд: 15  
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 40 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 00 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
14 цаг 20 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн байна.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байгаа.

“Үндсэн хуулиа дээдлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

**Нэг. “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Үндсэн хуулийн хуулиа дээдлэн зарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар оролцож байна. Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулъя.

Танилцуулгаа уншчихъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

2024 оны 6 дугаар сарын 3-нд хуралдсан Монгол Ардын намын Төв хорооны тэргүүлэгчдийн хурал улс оронд бүгд найрамдах засаг тогтоох тухай шийдвэр гаргасныг Төв хорооны бүгд хурлаар хэлэлцэн баталж харьяат бүгд найрамдах ардын засгийг явуулж улсын бүх дээд эрхийг Улсын Их Хурал мөн хурлаар сонгогдсон Засгийн газар хадгална гэж тогтжээ.

Энэ дагуу Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхдугаар хурал хуралдаж 2024 оны 11 дүгээр сарын 26-нд Ардын бүрэн эрхт Бүгд Найрамдах Улсыг тунхаглан Анхдугаар Үндсэн хуулиа баталсан билээ.

Уг Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд найрамдах Бүрэн Эрхт Ард Улс гэж улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн улсын аливаа эрх хэргийг Улсын Их Хурал тус хурлаас сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийдүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино гэж хэмээжээ.

Анхдугаар Их Хурал 1924 оны 9 дүгээр сарын 8-нд Нийслэл хүрээнд эхэлж Халхын 4 аймаг, Дөрөвдийн 2 аймаг, Алтай ба Хөвсгөлийн Урианхай хошууд, Дарьганга, Ховдын тариачин хошуу болон ардын цэргийн ангиудаас нийт 90 хүн, Их Хуралд төлөөлөгчөөр сонгогдсоноос 77 төлөөлөгч нь оролцжээ.

Анхдугаар Их Хурлаар олон чухал асуудал хэлэлцэж, шийдвэрлэсний дотор анхдугаар хурал Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр санал нэгтэй баталсан бөгөөд хаант ёсыг тайван замаар халж засгийн эрхийг ард түмэнд өгч ард иргэдийн оролцоотойгоор төрөө байгуулан төрийн байгууллагын зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоосон нь Анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдол юм.

Ийнхүү Монгол Улс 20 дугаар зууны хүн төрөлхтний улс төрийн дэвшилтэт үзэгдэл бүгд найрамдах байгуулалд шилжин орсон Ази тивийн анхны улсын нэг болжээ. Мөн Монгол Улс түүхэндээ анх удаа Бүгд найрамдах байгууллагыг тунхагласан Үндсэн хуультай улс болсон байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 06-нд Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж Анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх



тухай 64 дүгээр тогтоолыг баталж Улсын Их Хурлын даргын 2024 оны 117 дугаар захирамжаар уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан байгуулсан.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолд заасан Үндсэн хуулиа эрхэмлэн дээдлэх үзэл санааг иргэдэд тайлбарлан таниулах арга хэмжээний хүрээнд:

Үндсэн хуулиа дээдлэн залрах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна. 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан ардчилсан шинэ Үндсэн хуулиар Монголын ард түмэн бид тусгаар улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл, иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлон хэрэгжүүлэх эрхэм зорилго болгоно.

Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна хэмээн оршил хэсэгтээ тунхагласан нь Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх сахин биелүүлэхийн үндэс болсон Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулиа дээдэлж, түүний агуулга, үзэл санааг ойлгож, айл өрх бүр дээдлэн залахыг уриалж Үндсэн хуулиа сурталчлан таниулах үзэл санааг нь түгээн дэлгэрүүлэх Үндсэн хуулийн мэдлэгийг иргэд, хүүхэд, залуустаа олгох чиглэлээр түлхүү анхаарч Үндсэн хуулийн үзэл санаа, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх шатын боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусгах, тайлбарлан таниулахыг уриалах, нийт байгууллага, иргэний үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх, мэдэгтүн, сахигтун гэж даяар олноо зарлан тунхагласныг сахин биелүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд дараах зорилт зохицуулалтыг тусгалаа. Төрийн бүх байгууллага Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Үндсэн хуулийг дээдлэн залах, Үндсэн хуулийн үзэл санаа, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулахыг Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад даалгах.

Иргэн бүр Үндсэн хуулиа судлан мэдэж айл өрх бүр Үндсэн хуулийг дээдлэн залах Үндсэн хуулийн үзэл санаа, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, сурталчлахыг хэвлэл мэдээллийн байгууллагад уриалах.

Тогтоолыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад даалгах бөгөөд

тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

2. 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэх өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү?

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Эрх зүйт төрийн гээд анхдугаар Үндсэн хууль батлагдсан агуулга энэ талаасаа харахад ер нь бол Үндсэн хуульт улс орон болсон утгаараа бүгд найрамдах засаглалыг баталгаажуулсан.

Энэ утгаараа харахад бид нэг Үндсэн хуулийг тунхагийн шинж чанартай нөхцөл байдалд байлгаад баймааргүй байгаа юм. Хүмүүсийн ойлголт нэг тунхаг, нийгмийн гэрээ маш өрөөсгөл бөгөөд дутуу дулимаг ойлголтоор ханддаг.

Хорооны Засаг дарга нар анхан шатын баг хороон Засаг дарга нар байдаг юм уу, Төрийн байгууллагын ажилтнууд Үндсэн хуулийг очоод асуухад зүйл заалтыг нь мэддэггүй юм уу уншиж үзээд тэрийгээ бас ойлгодоггүй талууд их олон тохиолддог.

Үүнийг бид нөгөө миний зүгээс хэлж байгаа шүүмжлэл биш, бодит амьдрал дээрээ ийм байгаа гэдгийг бол мэдэж байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр нэг 3, 4 юм анхаармаар байгаа юм. Агуулга болоод тэгээд энэ одоо юу гэдэг юм тэр 2 дугаар иргэдийн оролцоо ч гэдэг юм уу, төрийн байгууллагад даалгаж байгаа асуудлууд дээр болохоор нөгөө сургалтын агуулгад суулгана, түгээн дэлгэрүүлнэ ч гэдэг юм уу иймэрхүү зүйл бичээд орхичихоор эргэж нөгөө танилцуулагддаг, нөгөө эргэх холбоо нь алга болчихоод байгаа юм.

Тэгэхээр яг нөгөө одоо энэ чинь бид нарын харилцаа бүх юм сошиал медиа платформ дээр юм уу нөгөө иргэдийн хоорондын харилцаа их өөр цаг үед орчихсон.

---

Энэ тогтоолууд, энэ үг өгүүлбэр дээр өөрчлөлт оруулахгүй бол дахиад л нөгөө арай өмнөх цаг үеийн сэтгэлгээтэй хүмүүсийн бичсэн зүйлийг гаргаж эвхмэл юу эмхэтгэх байдаг юм уу ямар нэг юм гаргангуутаа тэрийгээ ажил хийсэн болгочхож байгаа.

Тэгэхээр нөгөө шинэ цаг үе буюу ирж байгаа энэ цаг үе дотор шинэлэг байдлаар ингээд санаачлах энэ чиглэлийн заалтуудыг оруулахдаа жоохон дутуу орхичихсон байна уу? Би үүнийг тогтоолын төслөөс гүйцэд харахгүй байна уу? Энэ талаар хэр бодож байгаа юм бэ? Жаахан өөрчлөлтийн саналууд оруулах гээд байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батбаатар гишүүн санал хэллээ тиймээ?

Асуултад Баасандорж дарга хариулах уу? 4 дүгээр микрофон.

**Б.Баасандорж:** Батбаатар гишүүний асуултад хариулья Баасандорж.

Бид энэ тогтоолыг боловсруулахдаа ер нь манай Үндсэн хуулийн маань 1992 оны Үндсэн хуулийн үзэл санаа нь яг тухайн үед Үндсэн хуулийг хэлэлцэн баталж байхад яг ямар агуулгуудыг хөндөж байсан юм.

Дээрээс нь хамгийн гол нь манай Үндсэн хуулийн судлаачид байдаг. Судлаачдынхаа бүтээл туурвилыг нэлээн үзэж судалсан.

Мөн дээрээс нь бид бусад оронд ер нь яг энэ Үндсэн хуулиа ер нь хууль дээдлэх Үндсэн хуулиа дээдлэн шүтэх гэж яг ямар арга хэмжээнүүдийг авдаг юм бэ? Төрийн бодлогын түвшинд ямар шийдвэр гаргадаг юм бэ гэдэг зүйлүүд дээр бид нэлээд судалж үзсэн.

Жишээ нь Финланд, Эстони, Америк зэрэг орнууд бол яг энэ Үндсэн хуулиа хүндэтгэж ялангуяа иргэний боловсрол буюу сургуулийн наснаас эхлэн иргэддээ ардчилал, Үндсэн хуулийн талаар системтэй боловсрол олгодог зүйлүүдийг ажлуудыг, хөтөлбөрүүдийг хийдэг нэлээдгүй хэдэн орнууд байгаа юм.

Мөн дээрээс нь нөгөө бусад оронд ч тэр манай Үндсэн хууль судлаач ч тэр ялангуяа Чимид багшийн Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс гээд судалгааны бүтээл байдаг.

Энэ судалгааны бүтээл дээр Үндсэн хууль дээдлэх үзэл дадлыг нийт иргэн, төрийн албан хаагч, улс төрчид, ялангуяа сая Батбаатар гишүүний хэлсэн ялангуяа залуу үеийнхэнд итгэл үнэмшил, дадал, зуршил болон төлөвшүүлэхэд зориуд анхаарал тавьж төрийн бодлогын түвшинд зохих шийдвэрийг гарган хэрэгжүүлбэл ардчиллын үнэт зүйлсийг ард түмний хүртээл болгож шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд чухал тус үзүүлнэ гэж энэ судалгааны материалдаа тусгаж өгсөн байгаа.

---

Яг энэ үүднээс нь бусад орон ч гэсэн төрийн албан хаагчид нь, иргэд нь, шүүгч нар нь тангаргаа өргөхдөө Үндсэн хуульдаа үнэнч байна гэж хэлж тангарагладаг.

Тэгээд Үндсэн хуулиа төрийн байгууллагууд нь, иргэд нь дээдэлдэг. Төрийн байгууллагууд нь залдаг ийм маш олон орнууд байгаа юм.

Тэгэхээр яг энэ утгаараа сая Батбаатар гишүүнтэй би санал нэг байна. Яг төрийн албан хаагчид маань Үндсэн хуулиа мэдэж байгаа төрийн албан хаагчид байна. Үндсэн хуулиа мэддэггүй, дээдэлдэггүй, утга учрыг нь ойлгодоггүй түвшнээс болоод янз бүрийн шийдвэр гаргадаг.

Одоо бид зарим нэг нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрүүд байдаг шүү дээ тиймээ. Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгодог ч гэдэг юм уу. Энэ чинь өөрөө яг Үндсэн хуулийн үзэл санаагаа Үндсэн хуулийн үзэл баримтлалаа яг ойлгож байна уу, мэдэж байна уу гэдэг дээр тод жишээ болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг таны саяын хэлсний дагуу энэ тогтоол дээр яг энэ гол гол үзэл санаанууд төрийн бүх байгууллагууд Үндсэн хуулиа яг ном журмынх нь дагуу залдаг байя. Мөн иргэддээ уриалъя. Иргэн айл өрх бүрдээ. Мөн сургалтын системдээ энэ агуулгуудыг оруулъя гэдэг үүднээс энэ тогтоолын төсөл дээр яг таны хэлсэн санаанууд туссан байгаа шүү агуулгаараа гэдгийг хэлэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Би үг хэлчихье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ц.Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Гэхдээ 3 дахь, 4 дэх заалтууд дээр асуулт байна. Энэ бүх шатын боловсролын байгууллагын сургалтын агуулгад энэ Үндсэн хуулийн талаарх ойлголт байдаггүй юм уу?

Үндсэн хууль, хүний эрх, эрх чөлөөний асуудлаар ерөөсөө хичээл заагддаггүй юм уу? ерөнхий болосролын сургууль, их дээд сургуулиудын сургалтын агуулгад үүнийг нэг тодруулж өгөөч? Уг нь байдаг шиг санах юм. Хүний эрх, эрх чөлөөний асуудал зайлшгүй л орох ёстой хичээл. Хэрвээ байгаа тохиолдолд, байдаггүй тохиолдолд сургалтын агуулгад тусгана гэж байна.

Үүнийг дагаад сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын авлага, гарын авлага номуудад өөрчлөлт орох уу? Гарах эдийн засгийн үр дүн тооцсон юм байна уу, үгүй юу? Гарын авлага номд нь энэ талын хичээл юмнуудыг сургалтын төлөвлөгөөнд нь оруулна гэсэн үг үү?

Үүнийг нэг тодруулж өгөөч. Энэ хэвлэл мэдээллийн байгууллагууд байгаа юм. Уриалсугай л гээд өнгөрчихмөөргүй байгаа юм. Бараг үүрэгжүүлмээр ийм шинжтэй байгаа юм. Одоо энэ манай Монгол Улс чинь энэ зурагт телевиз харахад хэчнээн ч олон суваг байдаг юм. Хэрэгтэй хэрэггүй Солонгосын, Хятадын сериалуудыг ямар ч их гаргадаг юм. Үгүй ээ энэ зурагт асаахаар л нэг ийм олон ангит цуврал кино. Гаднын үзэл суртлыг сурталчилсан ахуй амьдралыг сурталчилсан яг хэрэгтэй гэдэг юм уу энэ Үндсэн хууль, хүний эрх чөлөөний чиглэлээр сургалт хичээл, нэвтрүүлэг, контент юм гэж үнэндээ алга даа. Тэр парламентын суваг телевиз чинь ч хүртэл энэ чиглэлээр хэр юм явуулдаг юм.

Тэгэхээр үүнийг зүгээр ингээд, ингээд уриалаад, ингээд уриалаад нэг тогтоол гаргаад орхичихье энэ яг бахь байдаг хэвээрээ л байна. Ямар ч өөрчлөлт үр дүн гарахгүй.

Харин энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудаа тэр сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллагуудыг амаар нь гартал мөнгөөр угжиж байдаг асуудлаа больж энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудад энэ чиглэлээр харин ч одоо төсөв мөнгийг баталж өгдөг.

Энэ чиглэлээр телевиз, нэвтрүүлэг, контент юм хийж олон нийтийн хүртээл болгож ой тойнд нь ортол ингэж тулж ажиллаж байж энэ ойлголтыг түгээн дэлгэрүүлэх асуудал бас үр дүн гарах юм болов уу л гэсэн чиглэлтэй байна.

Тэгээд энэ дээр бас зүгээр ерөнхий байдлаар нэг тийм орчхоод байна даа хэвлэл мэдээллийн байгууллагад уриалсугай гээд л.

Тэгээд энэ дээр та бүхэн юу гэж бодож байна? Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж.

**Б.Баасандорж:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя аа Баасандорж.

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулахад яг энэ тогтоол маань өөрөө яг үндсэн 4 заалттай байгаа. Энэ үндсэн 4 заалттай тогтоолын маань 2 нь яг даалгаж байгаа заалт байгаа.

Хоёр нь яг уриалсан заалт байгаа. Уриалсан заалт нь бол бид иргэддээ айл эрх бүрдээ уриалж байгаа. Заавал бол биш яг уриалж байя гэж шийдэж байгаа.

Хоёрт нь мөн адил энэ хэвлэл мэдээллийн байгууллагууд буюу энэ төрийн бус байгууллагууддаа бид уриалж байгаа. Харин даалгаж байгаа нь бол яг төрийн байгууллага бүх шатын төрийн байгууллагад бид даалгаж байгаа.

Таны саяын яг хөндсөн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт буюу энэ хөтөлбөрт Засгийн газрын түвшинд яг энэ агуулгыг оруулахаар судлаад, төлөвлөөд, тэгээд танилцуулах үүргийг өгөөд даалгаж байгаа юм.

Одоо бол манай ерөнхий боловсролын системүүдэд Хүн ба нийгэм гээд хичээл ордог. Боловсролын системд байдаг.

Тэгэхээр энийгээ улам гүнзгийрүүлээд яг тэр бусад орны жишигт нь хүргээд мөн Их Хурлын Тамгын газраас 2021 оноос яг энэ Үндсэн хуулийнхаа үзэл санааг ерөнхий боловсролын сургуулиуддаа ойлгуулах үүднээс зарим хичээлүүдэд орж байсан тийм сайн туршлагууд байгаа.

Тэгэхээр энэ аль аль талаасаа эд нарыгаа улам гүнзгийрүүлээд Засгийн газрын түвшинд төлөвлөөд боловсруулаад оролцуулахаар яаж байгаа юм? Тантай харин Ц.Сандаг-Очир гишүүний энэ 3 дахь асуулт дээр нэг зүйл дээр санал нэг байна. Яг энэ 3 дахь заалтыг хэрвээ гишүүд маань хэрвээ Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд маань зөвшөөрвөл нэг хугацаатай, хугацааг нь арай нэг боломжит хугацаа тавиад хэрэгжих хугацааг нь хойш нь тавих нь зөв юм болов уу гэсэн та бүхэн зөвшөөрвөл тийм нэг санал байна 3 дахь заалттай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Алтангэрэл гишүүнээр тасалъя. Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” тогтоолыг дэмжиж байгаа. 2020 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Баттулгыг байхад Үндсэн хуулиа иргэн бүр судалж уншиж мэдье, айл өрх болгон өрх гэртээ дээдэлж залъя гэдэг уриалга гаргаад зарлиг гаргаач гэсэн санал хүргүүлж байсан.

2022 онд бас Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхэд бас энэ Үндсэн хуулиа дээдэлж залах зарлиг гаргаач гэсэн саналыг бас 2022 онд хүргүүлж байсан юм. Үндсэн хууль Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын баталгаа, хүний эрх, эрх чөлөөг шударга ёс үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, түүх, соёл уламжлалаа хадгалж чадах баталгаа. Тийм болохоор л бид Үндсэн хуулиа дээдэлж байх ёстой.

1924 онд Үндсэн хууль, Анхдугаар Үндсэн хууль баталж байх үед хаант засаглалыг халаад бид бүгд найрамдах засаглалтай болж байсан онцлог нь. 1992 онд бид бас анхдугаар ардчилсан шинэ Үндсэн хууль баталж байх үед бид төрийн байгууламжийн хувьд бүгд найрамдах засаглалтай байна. Төрийн байгууллын хувьд парламентын засаглалтай болно.

Улс төрийн тогтолцооны хувьд олон намын тогтолцоотой болно. Хүний эрх эрх чөлөөг дээдэлнэ. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг Монгол Улсдаа

байгуулна гэж зарлаж байсан онцлог нь. 2000 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Түүнийг дордуулсан 7 өөрчлөлт гэж ярьдаг.

Ерөнхийдөө одоо бас 1992 оноос хойш Монгол төрийн хувьд Засгийн газар бүтцийн хувьд нэлээн тийм тогтворгүй явж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор бид өөрчлөлт хийсэн. Харамсалтай нь сайжирсан гэж яригддаггүй. Үүнээс хойш үндсэндээ 2019 он хүртэл хугацаа нь 20 гаруй жилийн, 30 орчим жилийн хугацаанд ерөнхийдөө нэг Засгийн газрын дундаж наслалт 1.6 жил.

Ерөөсөө л бүрэн эрхийнхээ хугацаа дуусгаж байсан Засгийн газар бараг байгаагүй. Ийм байдлаар төр тогтворгүй төрд хямрал нүүрлэсэн. Төрийн бодлого уялдаа холбоогүй. Төрийн эрх барих хууль тогтоох энэ дээд байгууллага гүйцэтгэх засаглал нь хоорондоо ажил төрөл нь таарахаа больчихсон байсан.

Энэ асуудлыг шийдэх гэж бид 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой тэнцвэртэй болгох энэ төрийг тогтвортой бодлого нь тогтвортой байх үйл ажиллагаа нь тогтвортой байх бодлого нь тодорхой байх хоорондоо уялдаатай байх асуудал.

Бид 2019 оны Үндсэн хуулиар шийдэж чадсан. Хөгжлийн бодлого төлөвлөлт урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байна.

Засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын эрх мэдлийг хязгаарлах энэ асуудлуудыг 2019 оны Үндсэн хуулиар бид шийдсэн.

Үндсэндээ энэ үеэс хойш Засгийн газар огцрох асуудал байхгүй 6, 7 жил болж байна.

Тэгэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт харьцангуй зөв болсон юм болов уу гэж боддог. Одоо бид 126 гишүүнтэй парламентын хувьд холимог тогтолцоотой. 2022 онд Үндсэн хуулийнх нэмэлт сүүлийн өөрчлөлтөөрөө бид үндсэндээ парламентын засаглалаа улам бэхжүүлж баталгаажуулсан.

Тийм болохоор бид цааш цаашдаа энэ түүхүүдийг санаж мэдэж цаашдаа Монголчууд төрөө дээдэлдэг ард түмэн, төрийн минь сүлд өршөө, төр төвшин, түмэн олон амгалан байх болтугай гээд дээдэлдэг ард түмэн. Энэ хойч үедээ төрийн бодлого зөв бол, төрийн бодлого уялдаа холбоотой, төрийн бодлого тогтвортой бол улс орон хөгждөг юм. Ард иргэд нь аз жаргалтай амьдардаг юм.

Тийм болохоор төрийн бодлого алган дээр багтсан эх орон гэж хэлдэг энэ Үндсэн хууль дотор төрийн бодлого багтдаг юм шүү гэдгийг бас ойлгуулах, сурталчлах, таниулах үүднээсээ энэ Үндсэн хуулийг дээдлэн залах тухай тогтоол гаргаж байгаа нь зөв өө.

Ийм байдлаар цаашдаа бид бас энэ төрийн бодлого залгамж чанартай байгаасай, хадгалагддаг байгаасай, үр хойч үед нь бас уламжлагдаж үлдээсэй гэдэг.../минут дуусав/.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батын Батбаатар гишүүн үгээ хэлье.

**Б.Батбаатар:** Үндсэн хуулийн асуудлаар дээдлэн залах тухай тогтоол гаргахыг дэмжиж байна, нэгдүгээрт.

Гэхдээ бид зарим зүйлийг анхаарах ёстой тогтоол гаргахдаа. Өнгөрсөн Үндсэн хуулийн түүхүүдийг бүгдээрээ мэдэж байгаа. Сүүлийн үед орсон Үндсэн хуулийн өөрчлөлтүүдийг мэдэж байгаа.

Өнөөдөр бид Үндсэн хуулиа яриад энд сууж байна. Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ой гэдэг энэ хүрээнд энэ тогтоол гарч байгаа. Үндсэн хуулийг дээдлэн зална гэдэг чинь Үндсэн хуулиа даган мөрдөх тухай асуудал нэг номерт тавигдах байх. бид олон зүйлийг тавилга болгож хувиргасан. Соцын үед нь ном бол тавилга болсон. Энэ айл зөв айл гэж харагдахын тулд л тавьдаг тавилга болгосон. Бурхан тахил шүтээнээ тавилга болгож хувиргасан.

Монголын нууц товчоог бараг тавилга болгосон. Морин хуур Чингис хаанаа тавилга болгож хувиргасан. Яагаад энийгээ дээдлэн залаад байгаа юм. Яагаад энийгээ дахин шүтээд байгаа юм. Яагаад энийгээ мөрдөн дагаж мэдэгтүн, сахигтун гэж Үндсэн хуульд орсноор нь хүлээж авах ёстой юм бэ гэдэг тухай нь бодох хэрэгтэй. Тэгээд манай тогтоолын төсөл дээр болохоор дахиад нөгөө олон зүйл тавилга болсон шигээ явах тэр чиглэл рүүгээ мэдээж урьд нь гарч байсан олон тогтоолуудыг харсан байх.

Даалгаж байгаа боловч тэрийг нь ямар хугацаа, ямар орон зай, ямар хэмжээс нь тэр даалгасан зүйлийнхээ гүйцэтгэлийг нь хянах юм гэдэг нь алга. Тэрийг оруулмаар байна.

Дээрээс нь хэвлэл мэдээлэл олон нийтэд, тэд нар, хувийн өмчийн байгууллагууд Үндсэн хуулиар эрхийг нь өгсөн гэж байгаа юм. Үндсэн хуулийн асуудал бол бүх Монголчуудын дагаж мөрдөх ёстой амьдрах ёстой хэв журам.

Тэгэхээр энэ чиглэлд нь аливаа ажлыг зорилго, төлөвлөгөө, гүйцэтгэл, хяналт гээд ингээд явахад бол тэрний тодорхой хэмжээнд санхүүжилтийн асуудал байгаа учраас тэрийгээ хэлж чадахгүй ингээд орхичхоод уриалаад байна гэж ойлгоод байгаа юм. Үндсэн хуулиа ойлгож мэдэж байгаа нь Монгол Улс энэ 2 том их гүрний дунд туурга тусгаар улс байгаагийнхаа хувьд улс орны үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолын асуудал Үндсэн хуультай холбогдоно.

Тийм болохоор энэ дээр гаргах ёстой зүйлээ гаргах ёстой. Хэрэгжилтийг нь эргэж хянадаг, тодорхой асуудлыг шийддэг, тодорхой санхүү, асуудлуудыг нь шийддэг тэр чиглэл рүү явах хэрэгтэй. Тийм зүйлээс бид хэлээд хийвэл ямар нэг



байдлаар тодорхой хугацааны дараа юм уу, үйл явц дээр нь муу нэр авна гэдэг байдлаар ухарч нуугдах хэрэг байхгүй. Үндсэн хууль төрийн байгууллагуудын албан хүрээний төв оффис юм уу үүдний хүндэтгэлийн юм уу аль нэг танхимд нь нэг шоголтой баринтаг байж болохгүй. Үндсэн хуулийн доторх заалтууд нь тэр Төрийн албан хаагчдын баримтлах зарчим, иргэдийн эрхээ мэдэх зарчим, мэдэх эрх, тэр бүх зүйлийг нь хангасан зүйлүүд ил тод олонд агуулгаараа хүрдэг.

Энэ чиглэл рүү нь ажиллах хэрэгтэй. Тооцож болох цаг хугацаа орон зайн хэмжээстэй хариуцаж байгаа эзэн нь хариуцлага хүлээх боломжтой ийм тогтоол гаргадаг байхгүй бол ингээд даалгаад уриалаад яваад байвал бас хэцүү. Цааш цаашдаа үр дүн багатай байх юм гэж үзэж байна.

Тэгэхээр ингээд нэг 4 зүйлийн саналыг тогтоолын 4 заалт дээр Байнгын хороон даргад өгье.

Тэгээд үүнийг санал хураалгаад бусад гишүүд маань ч гэсэн анхаарч туслаасай гэж хүсэж байна. Ийм санал хураалгаж өгөхийг хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Уянгахишиг гишүүн үгээ хэлье.

**Г.Уянгахишиг:** Ер нь бол тогтоолыг дэмжиж байгаа. Энэ дээр найруулгын шинжтэй хэдэн санал байгаад байна.

Нэгдүгээрт болохоороо яг энэ толгой хэсгийн Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нийт байгууллага, иргэний үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх гэдэг үг байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ өөрөө болохгүй агуулга байгаад байна. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хууль чинь өөрөө яг гол хүний эрх, эрх чөлөөг тунхаглаж байгаа үндсэн мэдээлэл тусгаар тогтнол энэ талаасаа ер нь бол Үндсэн хуулиа дагаад органик хуулиудыг баталж байгаа. Тэр органик хуулиуддаа үйл ажиллагаагаа нийцүүлэх, дагаж мөрдөх үүрэг нь бол угаасаа байгууллага иргэн бүгдэд нь байгаа.

Тийм учраас үүнийг нөгөө нийт байгууллага иргэний үйл ажиллагааг хуульд бүрнээ нийцүүлэх гэхээр нэг ийм хандлага нь дээрээс доошоо буюу нэг ийм захиран тушаах хэлбэртэй ч юм шиг болчихоод байна л даа.

Тэгэхээр яг энэ хэсгийг бол хасах нь зүйтэй болов уу гэдэг санаа санал байна. Өөрөөр хэлэх юм бол энэ Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлж мэдэгтүн, сахигтун гэж даяар олноо зарлан тунхагласныг сахин биелүүлэх зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоосугай гэвэл илүү зохистой болж сонсогдоод байна л даа.

Сая би уншихдаа зорилгоор дараах арга хэмжээ гэж хэлээгүй. Зорилгын хүрээнд гэж хэлдэг нь бас учиртай. Яагаад гэхээр энэ бол тэр зорилгын хүрээнд

хийгдэж байгаа олон ажлын нэг нь. Зөвхөн одоо Үндсэн хуулиа зарлах биш. бид энэ бүх үйлчлэлийн хүрээнд хуулиудаа нийцүүлэх, энэ хуулийн шинэтгэл энэ бүх юм чинь өөрөө Үндсэн хуульд нийцүүлэх ийм саналаар явж байгаа учраас.

Дараагийн нэг санал болохоороо энэ 3 дугаар зүйл дээр нэг 2 агуулга л холилдчихсон юм шиг санагдаад байх юм. Бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусгана гэхчхэн байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ чинь одоо яг Засгийн газар холбогдох төрийн байгууллагууд гэхээс илүү Боловсролын яам л хийх үү гэж бодоод байна л даа.

Харин Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагууд бол өөрөө үйл ажиллагаагаа Үндсэн хуульд нийцүүлэх төрийн байгууллага, төрийн албан хаагч нарт түгээн дэлгэрүүлэх гэдэг энэ талаасаа дахиад тусдаа нэг агуулга нь яваад байна уу даа гэж нэг хараад байна.

Тэгэхээр 3-ыг нэг 2 хуваагаад найруулчихвал зүгээр юм болов уу? Зүгээр техник юунд бол 4 дээр хэвлэл мэдээллийн байгууллагад гэхчхэн байгаа. Энэ бол нөгөө хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай гэхгүй бол энэ өмнөх нь бусад төрийн байгууллагад гэсэн учраас нэг тоон дээр хэлж болоод байгаа.

Дөрөв дээр бол хэвлэл мэдээллийн байгууллагад гэж нэг тоон дээр хэлж болохгүй. Энэ олон тоон дээр хэлэгдэх ёстой. Нэг ийм хэдэн санал байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Уянгахишиг гишүүн саналын томъёоллоо бичээд албан ёсоор өгчих.

Алтангэрэл гишүүн үгээ хэлье.

**О.Алтангэрэл:** Монгол Улсын Их Хурлаас энэ Анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ойг угтаж ийм тогтоол гаргах нь ер нь зүйтэй байна. Тэгээд яах вэ би нөгөө Батбаатар гишүүний хэлсэн дээр үг хэлчихье гэж бодсон юм. Уг нь үг хэлье гэж бодсонгүй. Яах вэ морин хуур нэг ийм залсан юунууд байгаа л даа байгууллага руу орохоор. Жишээлбэл ХЗДХЯ-ны харьяа байгууллагууд руу орохоор бүгдээрэнд нь үүдэнд нь Монгол Улсын Үндсэн хууль байж байгаа. Тэгээд энэ дээдэлж сахиад тавилга шиг болтугай тавихаас ч авхуулаад л тэгээд л энэ хүндлэх, дээдлэх юм эхэлнэ. Тэр бол зөвхөн нэг хэсэг нь, зөвхөн нэг хэсэг нь.

Харин энэ бүх шатны сургалт гэдэгт Уянгахишиг гишүүний хэлсэн дээр бол Жишээлбэл байгууллага дотроо өөрсдөө сургалтын хөтөлбөр байдаг. Бүх байгууллагууд төрийн байгууллагууд энд тусах байх. Тэгээд бүх төрлийн сургалтын агуулгад тусах байх гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ бол ганцхан Боловсролын яамны үүрэг ч биш. Тухайлах юм бол Хууль зүй, дотоод хэргийн яам хууль тогтоомжийг болоод хөтөлбөрийг сурталчлах ажил хэрэгжүүлдэг.

Тэгээд манайх бол жишээ нь сүүлийн үед энэ Анхдугаар Үндсэн хуулийн ойтой холбоотойгоор энэ сурталчлан таниулахтай холбоотой үйл ажиллагаан дээр дэмжлэг үзүүлээч гэсэн хүсэл энэ олон нийтийн байгууллагуудын зүгээс нэлээн ирж байгаа.

Тэгэхээр энэ бол бидэнд тэр үйл ажиллагаагаа зохион байгуулахад нэг эрх зүйн үндэс нь болох байх.

Тэгэхээр бид ер нь энэ дээдлэн залахыг уриалж байж энэ бол бид нарын одоо энэ эрх зүйн ухамсар дахь хамгийн гол баримтлах жанжин шугам.

Бидний хамгийн үнэт зүйл манай Чимид багшийн хэлснээр Монгол хүний тэмүүлэх эрхэм зүйлийн нэг нь Үндсэн хууль байж ээ гэсэн. Энэ зорилгыг биелүүлэхэд бид энэ Анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ой дээр энэ тогтоолыг гаргаж байгаа явдал нь ач холбогдол өгнө гэдэгт ерөөсөө эргэлзэхгүй байна. Бид сайн анзаараад харвал анх морин хуурыг дээдлэн залах тэр шийдвэр гарч байсан үеэс хойш өнөөдөр Монгол Улсад морин хуурын сургалт бүх зүйл сайжирсан.

Мэдээж айл болгон нэг тавилгатай болсон. Морин хуур гэдэг. Энэнтэй адилхан ер нь ингээд оюун санааны ухамсрын түвшинд Монгол хүний соёл ухамсрын түвшинд ингэж дээдлэн зална, тэгээд тайлбарлан таниулна, түгээн дэлгэрүүлнэ гэдэг энэ утга санаа яг энэ хэлбэрээрээ сууж хэвшсэн учраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь дэмжиж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд санал хэлж дууслаа. Үндсэндээ бол улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг батлан бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж төрт ёс түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж гээд энэ бүх хүрээндээ бол бид Үндсэн хуулиа бол дээдлэн залах нь бол зайлшгүй хэрэгтэй юм гэдгийг бол гишүүд маань хэллээ.

Ингээд гишүүд санал хэлж дууслаа. Санал хураалтдаа оръё.

Иргэн бүр Үндсэн хуулиа судлан дээдэлж, айл өрх бүр Үндсэн хуулиа дээдлэн залахыг уриалсугай гэснийг иргэн бүр Үндсэн хуулиа судлан мэдэх боломжтой Үндсэн хуулийн хялбаршуулсан болон зурагт хувилбаруудыг нийт иргэдэд үнэ төлбөргүй хүргэж айл өрх бүрт Үндсэн хуулиа байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагад даалгасугай гэсэн байна.

Батын Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй томьёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

---

## 6.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Тогтоолын төслийн гуравт Үндсэн хуулийн үндсэн хуулийн агуулга, Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, Монгол Улсын Засгийн газар болон холбогдох төрийн байгууллагад даалгасугай гэснийг Үндсэн хуулийн агуулгыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт шинэлэг аргаар тусган хичээлийн хөтөлбөр болон багш бэлтгэх залуу үед хүний эрх, тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлах цахим тоглоом санаачилгыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад удирдамж болгосугай гэж байна.

Батын Батбаатар гишүүний гаргасан саналын томъёоллын дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Төхөөрөмж ажилласангүй.

Санал хураалтыг дахин явуулах уу? Саяынх чинь ерөөсөө гарч ирсэнгүй. Тийм болохоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Дэмжсэн гишүүн алга байна.

Тийм болохоор саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тэгвэл ерөөсөө саяын гараар хураая гэснийг гараар хураая гэсэн зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хараарай хэд вэ? 9 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Тэгвэл санал хураалт.

Батын Батбаатар гишүүний гаргасан 2 дахь саналыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гурван гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа, Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, сурталчлахыг хэвлэл мэдээллийн байгууллагад уриалсугай гэснийг хэвлэл мэдээллийн байгууллагуудыг Үндсэн хуулийн талаар

тусгай нэвтрүүлэг, подкаст, сошиал медиа, контент хөгжүүлэн олон нийтэд хүргэж залуучуудын оролцоог дэмжихийг уриалсугай гэсэн байна.

Батын Батбаатар гишүүний гаргасан саналын томьёоллыг дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

3 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

4.Энэ тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс хойш дагаж мөрдсүгэй гэснийг энэ тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхэлж жил бүрийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд танилцуулахыг төрийн холбогдох байгууллагуудад даалгасугай.

Батын Батбаатар гишүүний гаргасан 4 дэх саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

2 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Уянгахишигийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Саналын томьёолол. Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх гэсний дараа нийт байгууллага иргэдийн үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх гэсэн хэсгийг хасах.

Уянгахишиг гишүүний гаргасан саналын томьёоллыг дэмжье гэсэн ийм томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Дэмжигдсэнгүй 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

8 гишүүн дэмжиж тогтоол батлагдлаа.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн танилцуулна.

---

Ингээд “Үндсэн хуулиа дээдлэн зарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

**Хуралдаан 40 минут үргэлжилж, 15 цаг 00 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**П.МЯДАГМАА**